



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагчийн дүгнэлтээр нийт 542,869,520 (таван зуун дөчин хоёр сая найман зуун жаран есөн мянга таван зуун хорь) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлт 79.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг “Булган АЗЗА” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал (Э.Пүрэвдэмбэрэл)-д үүрэг болгосугай.

2.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

3.1.Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.6.3, 3.15, 3.8 болон Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2-т заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн Гүйцэтгэх захирал (Э.Пүрэвдэмбэрэл)-д хууль тогтоомжийн дагуу хариуцлагын арга хэмжээ авах;

3.2.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

3.3.Зоон даваа дахь грааш болон бусад эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулж төрийн өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.4.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

4.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Э.Пүрэвдэмбэрэл)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1.Компанийн өөрчлөлт орсон газар эзэмших эрхийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх;

4.2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

4.3.Компанийн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, саналыг боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.4.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг технологийн зориулалттай тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухайн хуулийн 28.5-т заасны дагуу машин механизмын түрээсийн орлогоос 40 хувь буюу 4,800,000 (дөрвөн сая найман зуун мянга) төгрөгийг Төрийн сангийн 100900000703 тоот дансанд 2023 оны 2 дугаар улиралд багтаан төвлөрүүлэхийг Гүйцэтгэх захирал (Э.Пүрэвдэмбэрэл)-д үүрэг болгосугай.

6.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн, удирдлага зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

7.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

8.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
 газрын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
 305 дугаар тогтоолын хавсралт

“Булган АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн
 шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
 арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	Худалдан авалтын төлөвлөгөөт бус худалдан авалт	377,962.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах.
2	Шууд худалдан авалт	139,976,580	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.2-т заалтыг мөрдөж ажиллах.
3	Бичиг баримтны зөрчилтэй 2 тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд тусгах	-	2 тээврийн хэрэгслийн бичиг баримтын зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.
4	Үргүй зардал	20,130,240	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 тогтоолын 1.3, 1.5, 1.6 болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 тоот албан даалгаварын 5, 6 дугаар заалтыг мөрдөж ажиллах
5	Машин механизмын түрээсийн төлбөр /авторейдер/	4,800,000	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.5 заасныг мөрдөж ажиллах
6	Эзэмшиж буй газрын хэмжээний өөрчлөлт	983м.кв	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
Нийт хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн		542,869,520	(Таван зуун дөчин хоёр сая найман зуун жаран есөн мянга таван зуун хорин төгрөг)